



“ХӨРӨНГИЙН АЛТАН ТҮЛХҮҮР”
ХХК-Д

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2022.8.04 № ЦАТ-11/03/023.

танай 2022.7.27 -ны № 06-Т

Агентын өөрчлөлтийг бүртгэсэн тухай

Танай компаниас Г.Ганцогт агентыг нэгдсэн бүртгэлээс хасуулах тухай хүсэлт ирүүлснийг Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу хянаж үзлээ.

Дээрх журмын 6.7-д “Хороо үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтан болон брокер, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ” гэж заасны дагуу Ганбатын Ганцогт агентыг Хорооны нэгдсэн бүртгэлд хасаж бүртгэн өөрчлөлтийг хийсэн болохыг мэдэгдье.

Мөн журмын 6.2-т “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ” 6.2.2-т “үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын брокер, агент өөрчлөгдөх” гэж заасныг анхаарна уу.

